



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/183

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 46.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ гүйцэтгэгч сонгох ЗГХЭГ/20240102023 дугаартай тендерт 289,707,000 (Хоёр зуун наян есөн сая долоон зуун долоон мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Кибержаал” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Кибержаал” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш) томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Х.Цэнд-Аюуш

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

П. Хажидмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Мэдээлэл технологи дотоод сүлжээ
хариуцсан ажилтан)

Г. Алтанчимэг

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
бүртгэл мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн)

Ш.Дарьжав

(“Кибержаал” ХХК-ийн захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:


Б.Баярмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
ахлах мэргэжилтэн)

3.Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Х.Цэнд-Аюуш)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Адьяасүрэн)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ